



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/361

Булган сум

“Хүүхэд хайр ирээдүй” Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагаанд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны IV Хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” А/360 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг аймгийн хэмжээнд “Хүүхэд хайр, ирээдүй” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж, зохион байгуулах арга хэмжээний ерөнхий удирдамжийг 1 дүгээр, нэгдсэн төлөвлөгөөг 2 дугаар, шаардагдах төсвийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шаардагдах 23,520,880 (хорин гурван сая таван зуун хорин мянга найман зуун наяд) төгрөгийн 7,830,000 (долоон сая найман зуун гучин мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх зардлын Хүүхдийн хөгжил, хамгааллын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас, 5,500,000 (таван сая таван зуун мянган) төгрөгийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас, 6,490,880 (зургаан сая дөрвөн зуун ерэн мянга найман зуун наяд) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс, 3,700,000 (гурван сая долоон зуун мянган) төгрөгийг Булган сумын засаг даргын Тамгын газраас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр), Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал) нарт зөвшөөрсүгэй.

3. Тус үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал), аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг), Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга (Н.Батжаргал) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6325010502

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙГ УГТАН  
“ХҮҮХЭД ХАЙР ИРЭЭДҮЙ” УРИА ДОР ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА  
ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ УДИРДАМЖ

**Үндэслэл:** Ардчилсан хувьсгалын дараа 1991 оны 1 дүгээр сарын 24-нд Улсын Бага Хурлаас баталсан Хөдөлмөрийн тухай хуулийн “Нийтээр амрах баярын өдөр” гэсэн 32 дугаар зүйлийн 3-т “Эх үрсийн өдөр 6 дугаар сарын 1” гэж анх хуульчилснаар 1995 онд “Эх үрсийн баяр”, 2003 онд “Хүүхдийн баяр” хэмээн нэрлэн, бүх нийтийн амралтын өдөр болгон өнгөрүүлж байна.

НҮБ-ын Ерөнхий ассамблей “Хүүхдийн эрхийн тунхаглал”-ыг 1959 оны 11 дүгээр сарын 20-нд, “Хүүхдийн эрхийн тухай конвенц”-ийг 1989 оны 11 дүгээр сарын 20-нд баталжээ. Түүнд дэлхийн хамгийн олон буюу 191 орон нэгдэн орсны дотор Монгол Улс 1990 онд 5 дахь орон болон нэгдэн орсон байна. Энэ конвенцын үзэл санаанд нийцүүлэн УИХ-аас “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” хуулийг 1996 онд баталжээ.

Манай аймгийн хувьд нийт 60332 хүн ам оршин суудаг 0-18 насны 21039 хүүхэд багачууд байна. Энэ үзүүлэлтээс харахад нийт хүн амын 35 хувийг хүүхэд, өсвөр үеийнхэн эзэлж байна.

**Зорилго:** Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан, хүүхдийг эрүүл аюулгүй, хамгаалагдсан орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр олон нийтийн санал санаачилгыг өрнүүлж, “ХҮҮХЭД ХАЙР ИРЭЭДҮЙ” уриан дор эрүүл цэвэр орчинд баяр ёслолыг тэмдэглэн өнгөрүүлж, хүүхэд багачуудаа баярлуулах явдал юм.

**Хамрах хүрээ, хугацаа:** Булган сумын нийт хүүхэд багачуудыг хамруулан 2025 оны 06 сарын 01-ний 11:00-20:00 цагийн хооронд “Хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэн”-д тусгай хөтөлбөрийн дагуу, сум орон нутаг, байгууллагын хэмжээнд өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулна.

**Зохион байгуулагчид:** АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Цагдаагийн газар, Биеийн тамир спортын газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Булган сумын ЗДТГ, Боловсролын газар, Эрүүл мэндийн газар, “ЭБЦТС” ТӨХК Булган аймаг дахь салбар, УБХ, Булган сумын тохижилт үйлчилгээний анги.


**Зохион байгуулах үйл ажиллагааны чиглэл:**

- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн теле хөтөлбөр бэлтгэж, олон нийтийн сүлжээнд тавих (ХГБХХГ, АЗДТГ-ын ХМОНХА, ХЖТ, Булган сумын Соёлын ордон, СЗДТГ)
- Аймаг, сумын Засаг дарга нарыг хамруулан цахим мэндчилгээ бэлтгэн цахимаар түгээх
- “Хүүхдээ сонсьё” арга хэмжээ зохион байгуулах.
- Нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, нэгдсэн хөтөлбөр гаргах (СУГ, Булган сумын Соёлын ордон)
- “Эрүүл шүд” аяны хүрээнд Булган сумын хүүхдүүдийн шүдний эмчилгээ, эрүүлжүүлэх ажлыг эрчимжүүлэх.
- Баярын арга хэмжээг зохион байгуулах талбайн зураглал, схем гаргаж, байгууллагуудад тараах.
- Баярын арга хэмжээний нэгдсэн хөтөлбөр гаргаж, постерын эх бэлтгэх.
- Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтыг сайжруулах, хүүхдийн тоглоомын засвар үйлчилгээ, орчны цэвэрлэгээг сайжруулж, чимэглэх, нээлтийн арга хэмжээ зохион байгуулах.

- 06 сарын 01-ний өдрийг архигүй, хүүхдийн дэргэд тамхи татахгүй, авто машингүй өдөр байхаар аймгийн Засаг даргын шийдвэр гаргах.
- Байгууллага бүр гадна орчноо цэвэрлэж, чимэглэх.
- “Хүүхэд эрхэм хэрэглэгч” Хүүхдийн худалдааны гудамж ажиллуулах, нэгдсэн зохион байгуулалт хийх.
- Баярын арга хэмжээний өглөө 09:00-17:00 цагийн хооронд сумын төвийн зам хаах зохицуулалт хийж, аюулгүй байдлыг хангах.
- Хүүхдийн баярын нээлтийн үйл ажиллагаа. (“Булган хотын хүүхдүүд - 2025” урлагийн наадмын Булган сумаас шалгарсан шилдэг хүүхдүүдийн тоглолт)
- Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн хүүхдүүдэд аймгийн Засаг даргын гарын бэлэг гардуулах
- 6 сарын 1-нд төрсөн хүүхдүүдэд гарын бэлэг өгөх
- Тусгай хэрэгцээт хүүхдүүдэд тэргэнцэр болон бусад дэмжлэг олгох.
- 16 нас хүрсэн хүүхдүүдэд иргэний үнэмлэх гардуулах “Иргэний андгай өргөх ёслол” арга хэмжээ зохион байгуулах.
- Хүүхдийн жүжиг тоглох (ХЖТ)
- Хүүхдүүдэд зориулсан өртөөчилсөн тэмцээн, уралдаан зохион байгуулах (Соёл амралтын хүрээлэн)
- “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн хаалтын үйл ажиллагаа
- Нэгдсэн арга хэмжээний талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх
- “Хүүхэд эрхэм хэрэглэгч” Хүүхдийн худалдааны гудамж ажиллуулах

-----oOo-----

05... дугаар сарын 28...-ны өдрийн 136 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙГ “ХҮҮХЭД ХАЙР ИРЭЭДҮЙ”  
УРИАН ДОР АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ АРГА  
ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025.05.16


№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
<b>Нэг. Сургалт, хэлэлцүүлэг мэдээллийн арга хэмжээ</b>				
1.1	Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн теле хөтөлбөр бэлтгэн хүргэх.	05/26-30	С.Оюунзаяа (ХГБХХГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэх)	АЗДТГ-ын ХМОНХА, ХЖТ, Булган сумын Соёлын ордон, СЗДТГ
1.2	Аймаг, сумын Засаг дарга нарын мэндчилгээг бэлтгэн цахимаар түгээх.	05/28-30	АЗДТГ-ын ХМОНХА, Сумын нийгмийн ажилтан	ХГБХХГ, СЗДТГ, Хүүхдийн зөвлөл
1.3	“Хүүхдээ сонсьё” арга хэмжээ зохион байгуулах.	05/26-30	Сумдын Хүүхдийн төлөө зөвлөл	ЕБС
1.4	“Эрүүл шүд” аяны хүрээнд Булган сумын хүүхдүүдийн шүдний эмчилгээ, эрүүлжүүлэх ажлыг эрчимжүүлэх.	05/20-05/30	Булган Нэгдсэн эмнэлгийн Шүдний кабинетын эмч нар	Өрхийн эмнэлэг Нэгдсэн эмнэлэг Сургуулийн эмч нар
<b>Хоёр. Засвар чимэглэл, бэлтгэл хангах арга хэмжээ</b>				
2.1	Баярын арга хэмжээг зохион байгуулах талбайн зураглал, схем гаргаж, байгууллагуудад тараах.	05/27	Г.Алдармөнх СУАЖЗГ-ын дарга, С.Оюунзаяа (ХГБХХГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)	АЗДТГ-ын НБХ
2.2	Баярын арга хэмжээний нэгдсэн хөтөлбөр гаргах, постерын эх бэлтгэл хийж, гадаах самбарт байршуулах	05/27-30	АЗДТГ-ын ХМОНХА, С.Оюунзаяа (ХГБХХГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)	Булган сумын ЗДТГ
2.3	Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтыг сайжруулах, хүүхдийн тоглоомын засвар үйлчилгээ, орчны цэвэрлэгээ, тайз болон талбайг чимэглэх, нээлтийн арга хэмжээ зохион байгуулах.	05/22-31	Д.Бямбажаргал (Булган сумын Засаг дарга)	Булган сумын ЗДТГ

2.4	06 сарын 01-ний өдрийг архигүй, хүүхдийн дэргэд тамхи татахгүй, авто машингүй өдөр байхаар аймгийн Засаг даргын шийдвэр гаргах. (Хаагдах зам нь дээд 4-н замын уулзвараас Холбооны уулзвар, Онцгой байдлын уулзвараас доод 4-н замын хооронд хаах)	06.01-ний өдрийн 09:00 цагаас 16:00 цагийн хооронд	Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ, ЦГ	Сумын ЗДТГ, Аж ахуйн нэгж байгууллагууд
2.5	Байгууллага бүр гадна орчноо цэвэрлэж, чимэглэх.	05/29-31	Булган сумын ЗДТГ	Бүх төр, төсвийн байгууллага
2.6	“Хүүхэд эрхэм хэрэглэгч” Хүүхдийн худалдааны гудамж ажиллуулах, нэгдсэн зохион байгуулалт хийх. (Заасан газарт зохион байгуулах)	05/31-06/01	Булган сумын ЗДТГ	Д.Алтаншагай СХЗХ-ийн дарга
2.7	Баярын арга хэмжээний өглөө 09:00 - 20:00 цагийн хооронд сумын төвийн зам хаах зохицуулалт хийж, аюулгүй байдлыг хангах.	05/31-06/01	Б.Эрдэнэбилэг (ЦГ-ын дарга)	-
2.8	Схем зураглалын дагуу зөөврийн нойл байршуулж, байнгын ажиллагаатай байлгах	05/31-06/01	БСЗДТГ	ТҮА
2.10	Үзвэр үйлчилгээний хэсэгт 500 сандал зөөж, байршуулах	06/01	АЗДТГ-ын НҮА	-
<b>Гурав. Уралдаан, тэмцээн, соёл урлагийн нэгдсэн үйл ажиллагаа</b>				
3.1	Хүүхдийн баярын нээлтийн үйл ажиллагаа. “Булган хотын хүүхдүүд - 2025” урлагийн наадмын Булган сумаас шалгарсан шилдэг хүүхдүүдийн тоглолт (“Хүүхэд 100” тоглолт, зохион байгуулж, тоглолтод оролцогч хүүхдүүдэд хүндэтгэл үзүүлэх)	06/01	СУАЖЗГ, ХГБХХГ, Булган сумын ЗДТГ, Соёлын ордон, “Dream lounge”	Төр төсвийн бүх байгууллагууд, (САЦХүрээлэн)
3.2	Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн хүүхдүүдэд аймгийн Засаг даргын гарын бэлэг гардуулах.	06/01	АЗДТГ	ХГБХХГ, ХХҮГ, СЗДТГ, бусад холбогдох байгууллагууд
	6 сарын 1-нд шинээр төрсөн хүүхдэд гарын бэлэг гардуулах.			
	Тусгай хэрэгцээт хүүхдүүдэд тэргэнцэр болон бусад дэмжлэг олгох.	5/30		
3.3	16 нас хүрсэн хүүхдүүдэд иргэний үнэмлэх гардуулах “Иргэний андгай өргөх ёслол” арга хэмжээ зохион байгуулах.	05/30	СУАЖЗГ, ХГБХХГ	УБХ, БГ, Булган сумын ЗДТГ
3.4	“Унадаг дугуйн уралдаан” зохион байгуулах.	06/01	ЦГ, “ЭБЦТС” ТӨХК Булган аймаг дахь салбар	Булган АЗЗА ТӨҮГ Булган сумын тохижилт үйлчилгээний анги

3.5	<b>3-7 насны ангилалд</b> <ul style="list-style-type: none"> <li>➤ “Зохиолын баатрууд амилсан нь” маскот зохион байгуулах.</li> <li>➤ “Музейгээр аялсан нь” /үнэ төлбөргүй музей үзэх/</li> <li>➤ Сансрын аялал өртөө ажиллуулах</li> </ul>	06/01	СУАЖЗГ, ХГБХХГ	Т.Мөнгөнтуяа (Нийтийн номын сангийн захирал), Т.Бэхтөр (Музей дарга), С.Оюунзаяа (ХГБХХГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч) Хүүхдийн зөвлөл
3.6	<b>8-11 насны ангилалд</b> <ul style="list-style-type: none"> <li>➤ Хүүхэд, багачуудад зориулсан кино үзвэр, үйлчилгээ үзүүлэх.</li> <li>➤ VR виртуал музей /төлбөртэй/</li> <li>➤ Л.Толстойн зохиол “Буратино” хүүхдийн жүжиг (Хөгжимт жүжгийн театрын уран бүтээлчдийн шинээр найруулан тавьсан хүүхдийн жүжиг, төлбөртэй)</li> </ul>	06/01	ХГБХХГ, Музей	БГ, ХГБХХГ-ын кино танхим, Соёл амралтын хүрээлэнд, Хөгжимт жүжгийн театр
3.7	<b>12-18 насны ангилалд</b> <ul style="list-style-type: none"> <li>➤ Open mic арга хэмжээ зохион байгуулах.</li> <li>➤ Сэтгэл зүйн оношилгоо, үйлчилгээ үзүүлэх.</li> <li>➤ Скаут өртөө</li> <li>➤ 3x3 Сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулах</li> <li>➤ E sport цахим тоглоом тоглуулах</li> </ul>	06/01	ХГБХХГ	Соёлын ордон, БГ (сургуулийн сэтгэл зүйчид), БГ (Сургуулийн дизайн технологийн багш нар), Булган аймгийн хүүхдийн зөвлөл,
<b>Дөрөв. Гэр бүлийн гишүүдэд зориулсан өртөөнүүд</b>				
4.1	Гэр бүлийн буухиа тэмцээн	06/01	БТСГ	-
4.2	Номын өртөө /үлгэр ярих/		Номын сан	-
4.3	Эрүүл гэр бүл өртөө		ЭМГ	-
4.4	Гэр бүлийн зургийн студи		Фото студи	-

-----oOo-----

Аймгийн Засаг даргын 2025 оны  
05 дугаар сарын 28-ны өдрийн 4361 дугаар  
захирамжийн 3 дугаар хавсралт



**“ ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙГ ХҮҮХЭД ХАЙР ИРЭЭДҮЙ ”  
УРИАН ДОР АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ АРГА  
ХЭМЖЭЭНД ШААРДАГДАХ ТӨСӨВ**

№	Шаардагдах зардал	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Нийт
<b>Нэг. Хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтот бүлгийн хүүхдүүдэд өгөх гарын бэлэг</b>				
1.	Урлагийн шилдэг хүүхдүүдийн гарын бэлэг бэлдэх	100 ш	37,000	10,730,000
2.	Зорилтот бүлгийн хүүхдүүдийн гарын бэлэг бэлдэх	190 ш		
3.	Тусгай хэрэгцээт хүүхдүүдэд бэлэг өгөх	55 ш	100,000	5,500,000
4.	Шинээр төрсөн хүүхдэд гарын бэлэг	8 ш	100,000	800,000
<b>Дүн</b>		<b>355 хүүхэд</b>	<b>-</b>	<b>17,030,000</b>
<b>Хоёр. Нэгдсэн арга хэмжээнд шаардлагатай хэрэглэгдэхүүн</b>				
1.	Тайз чимэглэл	-	-	4,978,880
2.	Талбайн чимэглэл	-	-	1,512,000
<b>Нийт</b>				<b>23,520,880</b>
<b>Үүнээс:</b>				
- Аймгийн Засаг даргын хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх зардлаас – 13,330,000				
- Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс – 6.490.880				
- Булган сумын Засаг даргын Тамгын газраас - 3,700,000				

-----oOo-----